

2

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

П.Лувсандорж

Монголын эдийн засгийг хөгжүүлэх стратеги, бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны үндэслэл, онолын үзэл баримтлал нэн чухал. Онол үгүй амьдралыг харанхуй, амьдрал үгүй онолыг хоосон гэдэг. Олон улсын зэрэгцүүлсэн судалгаанаас, Монгол Улсын үндэсний эдийн засаг бол төвлөрсөн төлөвлөгөөт болон зах зээлийн эдийн засгийн элементүүдийг багтаасан шилжилтийн эдийн засаг; хөгжлийн суурийг тодорхойлогч хөгжиж буй эдийн засаг; хөгжлийн ирээдүйг тодорхойлогч глобаль эдийн засгаас хамааралтай зах зээлийн эдийн засгийн бүтцийн элементүүдийг өөртөө багтаасан олон эдийн засгийн холимог нэгэн тогтолцоо мөн гэсэн онолын нэгтгэсэн дүгнэлт гарч буй.

Ийм болохоор, Монголын эдийн засгийн шинэчлэл, хөгжлийн үйл явцад орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухааны шилжилтийн, хөгжлийн, зах зээлийн, глобаль эдийн засгийн онолуудыг улс орны тодорхой нөхцөлд нийцүүлэн бүтээлчээр хэрэглэх ёстой. Тухайлбал: хөгжилтэй зах зээлийн онол шууд буух хөрсгүй нөхцөлд түүнийг шатлалтайгаар шилжилтийн болгож хэрэглэх; хөгжиж буй эдийн засгийн онол хэт хуучинсаг байвал зах зээлийн болон глобаль эдийн засгийн онолоор баяжуулж хэрэглэх; глобаль эдийн засгийн онол шууд буух хөрсгүй байвал хөгжлийн болон зах зээлийн онолд зохицуулж хэрэглэх шаардлагатай. Энэ бол орчин үеийн эдийн засгийн онолын олон ургалч үзэл баримтлал мөн.

Хөгжихийн тулд үндэсний эдийн засгийн хэмжээг мэдэх нь чухал. Монгол Улс бол бага орлоготой, хөгжиж буй орон. Түүний эдийн засгийн хэмжээ 165, энэ бол дэлхийн улсуудын 165-т орж, сүүл барьж байгаа гэсэн үг. Гэтэл манай хөршүүд ОХУ=83; БНХАУ=132; Азийн хүчирхэг түншүүд Япон=14; Солонгос (өмнөд)=51; ЭЗХТЗ-ийн хүрээнд манайтай адил хөгжил багатай орнуудын тоонд багтаж байсан Вьетнам=159 хэмжээний эдийн засагтай байгааг олон улсын жишсэн судалгаа харуулж байна.

Монгол Улсыг дэлхийтэй жишвэл: дэвсгэр нутгийн 1.2 хувь ногдох бөгөөд хүн амын тоо, үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээгээр бүхэл тоо гарахгүй. Монгол Улс нэг хүнд ногдох ҮНБ-ний хэмжээгээр (1.463\$) их орлоготой орнуудын дунджаас 16 дахин, дунд орлоготой орнуудынхаас 4.1 дахин, бага

орлоготой орнуудын дунджаас 1.5 дахин тус тус бага байгаа юм. Түүнийг хөрш орнуудтай жишвэл: ОХУ-ынхаас 4, БНХАУ-ынхаас 2 дахин, Азийн хүчирхэг түншүүдтэй жишвэл: Японоос 16 дахин, Солонгосоос 9 дахин, хөгжлийн түвшин ойролцоо байсан Вьетнамаас 16 хувь бага байна. Олон улсын харьцуулсан судалгааны эдгээр тоо баримт Монгол Улсын үндэсний эдийн засгийн бүхий л чадлыг илтгэн харуулна.

Хөгжлийн стратеги хэрэгтэй. Ойрын 15-20 жилийн хугацаанд дунд орлоготой орнуудын түвшинд хүрэх, эс чадвал ойртох стратегийн зорилт дэвшүүлэх шаардлагатай. Үүний тулд тогтвортой, түргэн хөгжил хэрэгтэй. Тогтвортой гэдэг нь дэлхий нийтийн, түргэн гэдэг нь үндэсний захиалга. Хөгжиж буй орнуудын тухайд зөвхөн тогтвортой гэх нь хангалтгүй.

Тэр түвшинд хүрэх хугацааны талаар тодорхой тооцоо хийх хэрэгтэй. Бидний тойм тооцоогоор:

- дунд орлоготой орнуудын одоогийн түвшин 6000 \$
- жилд нэг хувиар өсөхөд 20 жилийн дараа 7200 \$

Энэ түвшинд Монгол Улс хүрэхэд жил дутмын 10 хувийн өсөлт хэрэгтэй. Энэ бол бараг боломжгүй өндөр өсөлт. Тийм болохоор дунд орлоготой орнуудын түвшинд хүрэх биш, ойртох ил буюу хөгжлийн стратеги дэвшүүлэх нь бодитой. Тэгэхдээ, жижиг эдийн засагт алив нэгэн аварга хүчтэн орж ирэхэд санаанд оромгүй өндөр өсөлт авчрахыг бодолцсон далд буюу нөөцийн стратегитай байх нь зөв.

Үндэсний эдийн засгийн хүч чадал, өрсөлдөх чадварыг байнга дээшлүүлж байж хөгжилд хүрнэ.

Монголын эдийн засаг гадны эх үүсвэрийн үлэмж хэмжээний оролцоотойгоор төлбөрийн тэнцлээ хангадаг.

Монголын эдийн засаг гадаад худалдааны алдагдалтай, экспортын хомсдолтой.

Монголын эдийн засаг төсвийн алдагдалтай, орлого, хуримтлал багатай.

Монголын хүн амын үлэмжхэн хэсэг ядууралд орсон, ажилгүйдэл ихтэй, дутуу ажил эрхлэлт түүнээс ч дутахгүй.

Энэ бүхэн гашуун боловч үнэн. Үндэсний эдийн засагт, аж ахуйн нэгжүүдэд, айл өрх бүрт нүүрлээд байгаа: -бүтээмж сулаас орлого бага, орлого багаас технологи дорой, технологи доройгоос бүтээмж сул; -бүтээмж сулаас орлого бага, ... гээд дахин давтагдах гачигдлын цагираг, дутагдлын эргүүлгээс гарах бүх талын арга замаа бодож олох хэрэгтэй. Үүний дээр төр засаг, пүүс, компани, айл өрх, иргэн бүрийн нэгдсэн хүч шийдвэрлэх үүрэгтэй. Үүнтэй холбогдуулан, хүн бүр бага балчраас эхлэн ... гэдэг шиг өндөр бүтээмж их орлого, их орлого шинэ технологи, шинэ технологи өндөр бүтээмж гэсэн уриа, лоозонг орон даяар ажил болгох бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлэх нь юу юунаас чухал. Учир нь хөгжилд хүрэхийн тулд дуудлага хэрэгтэй.

Эдийн засаг дахь төрийн үүргийг тодорхой хугацаанд нэмэгдүүлэх шаардлага байна. Төрийн бүтээлч үүргүүдийн үндэслэлгүй үгүйсгэлд няцаалт өгч, төрөө дээдлэх Монгол түмний уламжлалт ёс заншлыг хөгжлийн хөдөлгүүр болгож ашиглавал зохино.

Улс орноо хоцрогдлоос ангижруулах, хөгжилд хүрэх урт хугацааны стратеги, бодлого, хөтөлбөр боловсруулах үйл ажиллагаа хаана хамаарагдах вэ? Бодвол бодлого боловсруулах үүрэгтэй Улсын Их Хуралд хамаарагдана байх. Ийм үйл ажиллагаа бүрэн эрхийн 4 жилийн хугацаа, өөрийн хөтөлбөр,

ОУВС-ийн заавар, зөвлөмжинд баригдсан Засгийн газруудад яаж хамаарагдах нь тодорхой бус.

Шилжилтийн болон хөгжиж буй эдийн засагт төрийн үүрэг асар их, тэгэхдээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай харьцуулбал асар бага, Кейнсийн сургаалиас илүү, Фридманы номлол одоохондоо тохирохгүй. Төр энд нийтлэг үүргүүдээс гадна бас өвөрмөц шинэ үүргүүдийг гүйцэтгэнэ. Тухайлбал, хөгжиж буй орнуудад зайлшгүй хэрэгтэй үндэсний эдийн засгийн ирээдүйтэй “ялагч” гэж нэрлэгддэг шинэ салбар, шинэ үйлдвэрлэлийг бий болгох шинэ үүргийг Монголын төр гүйцэтгэх учиртай. Түүнээс гадна хөдөөгийн малчдыг хотын панзчдаас хамгаалах; өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дампуурлаас хамгаалах шинэ үүргүүдийг Монголын төр гүйцэтгэх учиртай.

Монголын төр татвар төлөгчдийн мөнгө, хувьчлалын орлого, гадаадын зээл тусламжийн хөрөнгө бүгдийг зохицуулж, заримыг эзэмшиж байгаа. Нэг үгээр, Монголын төр бол Монголын хамгийн том хөрөнгөтөн. Тодорхой жишээ: Монголын төр аж ахуй нэгжүүдийн цэвэр орлогын 40 гаруй хувийг төсөвдөө цуглуулж ДНБ-ний 20 гаруй хувийг хэрэглэж байгаа. Энэ хоёр баримт бол дээр дурдсан онолын дүгнэлтүүдийн тоон нотолгоо.

Үндэсний эдийн засгийн үндсэн эсүүд нь болсон аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн хүч чадлыг нэмэгдүүлэх асуудлыг төр засгийн анхаарлын гадаа, зах зээлийн үзэмжинд орхиж болохгүй.

“Борооны дараах мөөг” гэдэг шиг ханаа нийлүүлсэн ТҮЦ-үүд, мөрөө дарсан дэлгүүр, эмийн сан, зоогийн газрууд, шатахуун түгээх станцууд гээд ээлж дараалан зэрэг зэрэг гарч ирээд бөөн бөөнөөр сөнөж монголын иргэн, монголын нийгэм хохирч байна. Энэ бол хөгжиж буй эдийн засагт зах зээл муу ажилладагийн бодит жишээ. Энд зах зээлийн цоорхойг төрийн зохицуулалт нөхөх ёстой.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн 70-80, хүн амын 60-70 хувийг эзлэх хөдөөгийн хөгжил, шинэчлэлд онцгой анхаарах хэрэгтэй. Тэнд 250 гаруй мянган малчин өрхийн 80 гаруй хувь нь, илүүдэл бүтээгдэхүүн байхгүй гэсэн судалгаа байдаг. Тийм бол зах зээлд ороогүй гэсэн үг. Түүнээс гадна таван төрлийн малын ижил төрлийн бүтээгдэхүүн гаргадаг төрөлжөөгүй олон аж ахуй зах зээлд яаж орох вэ? гэсэн төвөгтэй асуудал шийдлээ олоогүй байна.

Зах зээлд орсон гээд байгаа бүх хэвшлийн 20-иод мянган аж ахуйн нэгжийн эдийн засгийн хүч чадал дорой байна.

1) Үйлдвэрлэлийн зардалд нийт ашгийн эзлэх хувь 40-50 хувьтай байгаа. Энэ бол чамалхааргүй үзүүлэлт, харин түүнийг цаашид яаж хадгалах, нэмэгдүүлэх талаар бодох л хэрэгтэй;

2) Харин хуваарилалтын дараа үлдэх цэвэр ашиг үйлдвэрлэлийн зардлын 5 хувь байгаа. Энэ бол чамлалттай үзүүлэлт, татварын дарамтыг цаашид бууруулах талаар бодох хэрэгтэй;

3) Гэтэл аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлогоос борлуулсан бүтээгдэхүүний өртгийг хасч тооцсон цэвэр орлогын 40 гаруй хувийг олон янзын татвар хэлбэрээр төсөвт төлж байгаа.

4) Татварын ачаалал их байхад аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадвар үндэсний хэмжээнд сул байна.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын хөрөнгө оруулалтад өөрийн хөрөнгийн оролцоо 30-аад хувь, гадаад эх үүсвэр 60 гаруй, банкны зээл 6 хувьтай байна. Энэ бол хуримтлал хийх, хөрөнгө оруулах чадавхи сул гэсэн үг. Мөнгөний

бодлогоор дамжуулан банкуудын үйл ажиллагааг удирдах боломж төрд бий. Эдийн засгийн хөгжилд банк, санхүүгийн секторын гүйцэтгэх үүргийг шинэ дээд түвшинд гаргаж нэмэгдүүлэх цогцолбор хөтөлбөр хэрэгтэй байна.

Эдийн засаг дахь төрийн оролцоо бол шинээр тавигдах хуучин асуудал. Харин эдийн засаг дахь иргэдийн оролцоо бол шинээр тавигдах шинэ асуудал. Зах зээлийн эдийн засагт иргэдийн оролцоо нэмэгдэх хэрээр төрийн оролцоо багасна. Зах зээлд иргэд суудлаа олоход нь төр туслах учиртай. Ингэж байж иргэний нийгэм эдийн засгийн үндэс суурьтай болно. Үндэсний эдийн засгийн хүч чадал, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх нь чухал. "Өөрийгөө засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас" гэсэн монгол үгийг монгол хүн бүр амны уншлага, амьдралын шүтээн болгох хэрэгтэй. Энэ үг маш өргөн утгатай, эдийн засгийн хувьд: хүн бүр хөдөлмөрлөгч, айл бүр үйлдвэрлэгч, төр нь болохоор, түмэн олны нэгдэл, бүтээлч хүч байна гэсэн үг.

Шилжилтийн арга, хэлбэрүүдийн талаар үнэлгээ өгөх цаг болсон гэж Нобелийн шагналт, Америкийн эдийн засагч, нэрт эрдэмтэн Жозеф Стиглиц үзэж "Глобальчлал ба түүний сүүдэрт талууд" гэсэн бүтээлийнхээ нэгэн хэсэгт шилжилтийн эдийн засагтай орнуудын амжилт, дутагдлууд, анхаарах асуудлуудыг өргөн хүрээтэй тусгасан байна. Тэрээр, шинэчлэлийг аажмаар хийх арга нь зүйтэй гэдгийг хожуу, арваад жилийн дараа л ухаарч, хүлээн зөвшөөрч байна. Чөлөөт өрсөлдөөн үйлчлэхгүй, эсвэл огт үйлчилж эхлээгүй байгаа нөхцөлд улсын монополийг хувьчлах нь эргээд хувийн монополийг үүсгэж, энэ нь хэрэглэгчдэд улсын монополиос ч хүнд тусдаг гэж хэлсэн байна. Монгол улс Азийн орон атлаа Вашингтоны Консесус гэж нэрлэгддэг Европ аргаар түргэн шилжих бодлого баримтлаж багагүй хохирол хүлээсэн сургамжтай.

Шилжилтийн эдийн засагтай орнуудын эдийн засгийн байдлыг тогтворжуулах, цаашдын өсөлтийг хангахад зөв бодлого, төр засгийн идэвхтэй үйл ажиллагаа чухал болохыг Ж.Стиглиц онцлон анхаарчээ. Бас үндэсний судалгаа, үндэсний зөвлөхүүдийн дүгнэлт, санал чухал болохыг сануулж хэлсэн. Тэрээр, тухайн улсын тухай барагтайхан мэдлэгтэй барууныхан бид төдийлөн тус болж чадахгүй л болов уу.

Бидний оруулах хувь нэмэр бол зохион байгуулалт, чөлөөт хэвлэл, мэдээлэл, нээлттэй орчин гээд ардчиллын үнэ цэнийг таниулж мэдүүлэхэд оршино гэж батлаж хэлсэн.

Дэлхийн эдийн засгийн глобаль асуудлуудын шийдлээс үндэсний эдийн засгийн хөгжил ихээхэн шалтгаалах болсон цаг үе. Хөгжиж буй орнууд, түүний дотор Монгол Улс, өөрсдөө шийдэж, өөрсдийн эрх ашгаа хамгаалсан эдийн засгийн бодлого явуулж, чадалтай төрийн захиргааны аппарат, бие даасан хүчтэй шүүх эрх мэдэлтэй байж, төрийн болоод хувийн сектор авлигалд автахгүй, нээлттэй байх нь маш чухал. Өөрсдийн эрхээ ч олон улсын байгууллагын өмнө тулгаж, өөрийн орны онцлог, эрх ашиг, сонирхлыг ил тод хэлж, өмнөх загваруудыг хуулбарлах бус өөртөө тохирсон төслүүд, хөтөлбөрүүд боловсруулж ажиллах хэрэгтэй болсон байна. Юуны өмнө, үндэсний эдийн засагт нөлөөлж чадах гол хүчин зүйл нь гадаадын хөрөнгө оруулалтыг өөгшүүлсэн орчинг бүрдүүлэх явдал гэжээ. Үүнийг төрийн захиргааны бүх шатанд анхаарч, эрх зүйн хүнд суртал багатай нөхцөл чухал байна. Авлигалд баригдсан захиргаа хөрөнгө оруулагчдыг айлгаж байдаг. Нийгэм, эдийн засгийн тогтвортой байдал, татварыг үр ашигтайгаар цуглуулах

механизм, өрийн сүлжээг багасгах арга хэмжээ зэрэг олон суурь асуудлыг улс ардынхаа төлөө гэсэн сэтгэлээр төрийн нэгдмэл аппарат нь хийж чадвал амжилтанд хүрэх юм.

Ж.Стиглиц өөрийн судалгааг нэгтгэн дүгнэж, “Хөгжил гэдэг хэдэн хүнийг баян болгохыг хэлэхгүй. Хөгжил бол нийгэм, эдийн засгийн суурь өөрчлөлт, ядуугийн зовлонгүй, эмнэлэг, сургууль зэрэг нийгмийн халамж бүхий, хүн бүхэн өөрийн амьдралыг зохион байгуулахад нөхцөл нь бүрдсэн тийм байдлыг хэлнэ. Тиймээс ч хөгжлийг хэдхэн хүн бус, хувь заяа нь шийдэгдэж буй бүх л улс орны төр засаг, эрдэмтэн, эдийн засагч нарын оролцоо, санал шийдэх учиртай. Ингэж байж л глобальчлал “хүнлэг” чанартай болно.” гэсэн сургамжтай үг хэлсэн байна. Үүн дээр бид глобальчлал бол хэдэн орон хэт баяжихыг хэлэхгүй. Глобальчлал бол дэлхий дахинд нийгэм, эдийн засгийн суурь өөрчлөлт авчрах, ядуугийн зовлонгүй, нийгмийн халамж бүхий, улс орон бүхэнд өөрийн амьдралыг зохион байгуулах таатай нөхцөл бүрдүүлж чадах тийм байдлыг хэлнэ. Тэгсэн нөхцөлд глобальчлал нь бүх нийтийн, бүх дэлхийн хөгжлийн уриа дуудлага, бодит хүч болж чадна. Энд хөгжсөн орнуудын, олон улсын байгууллагуудын хүчтэй туслалцаа, НҮБ-ын идэвхтэй оролцоо нэн чухал гэж нэмж хэлмээр байна.

Глобальчлалын үеийн дэлхийн эдийн засгийн хөгжлийн хандлага шилжилтийн болон хөгжиж буй эдийн засагт зарчмын нөлөөтэйг хөгжлийн стратеги, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд харгалзан үзвэл зохино. Глобаль эдийн засгийн шинжлэх ухааны үндсэн дээр хөгжлийн эдийн засгийн онолуудыг шинэчлэн баяжуулах бодит шаардлага байгаа нь бас илэрхий.

Эдийн засгийн глобальчлал нь үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг дэлхийн түвшинд гаргахыг шаардана. Өөрөөр, үндэсний эдийн засгийн бүтэц, үйл ажиллагаанд суурь өөрчлөлт хийнэ гэсэн үг. Энэ бол өнөөдрөөс эхлэх алс хэтийн стратеги. Энэ стратегийг хэрэгжүүлэхийн тулд үндэсний эдийн засагт дэлхийн нэртэй пүүсүүд, үндэстэн дамнасан корпорациудын төлөөллийг бий болгох шинэ том зорилт тавьж ажиллах шаардлагатай.

Алс хэтийн стратеги хэрэгжих хүртэл амьдрах шаардлагатай, үүний тулд үндэсний эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдийг сонгож хөгжүүлэх ойрын зорилтыг алс хэтийн стратегийн хүрээнд хэрэгжүүлэхээс өөр аргагүй. Энд үндэсний эдийн засгийн үнэмлэхүй болон харьцангуй давуу талуудыг ашиглах, шинэ харьцангуй давуу тал бий болгох хөгжлийн онолууд хэрэг болно.

Үндэсний эдийн засгийн хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй үйлдвэрлэл, үйлчилгээний шинэ салбар, шинэ бүтээгдэхүүн бий болгох тодорхой асуудлуудаар НҮБ, олон улсын байгууллагууд, хөгжилтэй орнуудын засгийн газар, нэртэй пүүсүүд, үндэстэн дамнасан корпорациудын төлөөлөгчдөд үндэсний төсөл, хөтөлбөр боловсруулж туслалцаа авах ажлыг санаачлагатай, өргөн хүрээтэй зохион байгуулах нь эдийн засгийн глобальчлалын дэлхийн хандлагад нийцнэ.